

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

IV

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



18-19 апреля, 2019. Улан-Батор

Сборник докладов

Санкт-Петербург — Улан-Батор
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Ответственный редактор: Академик С.Чулуун
Научные редакторы: доктор филол. наук И.В.Кульганек
Ph.D Н.Хишигт
Редакторы, составители: Ph.D Б.Нацагдорж
канд. филол. наук. Н.С.Яхонтова

Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Сборник докладов IV международной научной конференции. 18—19 апреля 2019 г. Улан-Батор. Россия. СПб.—УБ. 2021 г. —276 с.,

Сборник представляет собой собрание докладов IV международной научной конференции “Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”, организованной Институтом истории и археологии МАН, Ассоциацией международных монголоведов и Институтом восточных рукописей РАН в г.Улан-Батор, 18—19 апреля 2019 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов. В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Институт истории и этнологии МАН, 2021 г.
© Институт восточных рукописей РАН, 2021 г.
© Международная ассоциация монголоведов, 2021 г.

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОЛОН УЛСЫН
МОНГОЛ СУДЛАЛЫН
ХОЛБОО



ОРОСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

IV

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2019 оны 4 сарын 18-19
Монгол улсын Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун

Эрдэм шинжилгээний редактор:

Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек

Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт

Редактор, эмхэтгэгчид:

Түүхийн ухааны доктор (Ph.D) Б.Нацагдорж

Хэлшинжлэлийн дэд эрдэмтэн Н.С.Яхонтова

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга

- IV. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Монгол улс, Улаанбаатар хот. 2019 оны 4 дүгээр сарын 18-19. Санкт-Петербург-Улаанбаатар., 2019 г. 276 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн болон Олон Улсын Монгол судлалын холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 18-19-нд Монгол улсын Улаанбаатар хотноо “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 4 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм. Эмхэтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны байдал, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-9919-9646-7-2

DOI 10.25882/z7ch-tr43

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2021

© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2021.

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2021.

MONGOLIAN
ACADEMY OF
SCIENCES
Institute of History
and Ethnology



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

IV

International Conference
Under the Patronage of the President of Mongolia



April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia

Proceedings

St. Petersburg — Ulaanbaatar
2021

HHA 63.4
ДAA 930.1
M-694

Managing Editor: Academician S.Chuluun
Scientific Editors: Dr.Sc. (Philology) I.V.Kulganek
Ph.D (History) N.Khishigt
Editor, compiler: Ph.D (History) B.Natsagdorj
Cand. Sc. (Philology) N.S.Yakhontova

Cultural heritage of the Mongols: manuscripts and archival collections. Papers of the IV International Conference, April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia. St.Petersburg —Ulaanbaatar 2019, 276 pages.

This is a collection of papers, presented at the Fourth International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences, the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in Ulaanbaatar on April 18-19, 2019.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples. The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Institute of History and Ethnology, MAS 2021
© Institute of Oriental Manuscripts, RAS 2021
© International Association for Mongol Studies, 2021

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

Өмнөтгөл (С.Чулуун)	9
<i>Г.Ариунтуяа</i>	
Монгол Улсын Үндэсний Төв Архив дахь Ж.Цэвээний хувийн хөмрөг	11
<i>Д.Баярсайхан</i>	
Монголчуудын тухай XIII-XIV зууны Армян сурвалжийн тойм	23
<i>Ts.P.Vanchikova</i>	
Folklore Heritage of the Buryats in the Funds of the COMX and Problems of its Research and Conservation	35
<i>Ж.Гэрэлбадрах</i>	
Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга	43
<i>Л.С.Дампилова</i>	
Шаманские материалы в фонде Т.К.Алексеевой в ЦВРК ИМБТ СО РАН	57
<i>Ж.Долгосүрэн</i>	
Эрдэмтэн, зохиолч, найруулагч, орчуулагч Э.Оюун: хэвлэгдээгүй гар бичмэл, намтрын баримтууд	65
<i>Г.А.Дырхеева</i>	
Традиционная письменная культура Бурят: социолингвистический аспект	73
<i>Г.А.Гребенищикова</i>	
Монголия в планах Военного и Морского ведомств России в 1903-1913 годах	84
<i>В.Ю.Жуков, И.В.Кульганек</i>	
«История монголов» О.М.Ковалевского: первое прочтение	98
<i>И.М.Захарова, М.В.Мандрик</i>	
К вопросу о деятельности Советника при Монгольском правительстве П.А.Витте	107
<i>С.Мөнхсайхан</i>	
Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдийн хэл шинжлэлийн ач холбогдол хийгээд сурвалж бичгийн үнэ цэнэ	121
<i>Б.Нацагдорж</i>	
Тод үсгийн нэгэн захидлаас <i>Ойрад</i> хэмээх нэрийн тухай тодруулах нь	136

<i>Д.А.Носов</i>	
Россыпи документов В.А.Казакевича: отчеты о поездках по Монголии 1923—1925 гг.	149
<i>К.В.Орлова</i>	
Документальное наследие калмыков: письма калмыцких ханов	160
<i>Р.Ю.Почекаев</i>	
Суд и процесс в монгольских «Хождениях в ад»	167
<i>Г.Сэр-Од</i>	
Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх Тамга, захирлага, тэмдгийн цуглуулга хөмрөг	176
<i>М.В.Федорова</i>	
Монгольские фотоколлекции конца XIX — начала XX вв. в собрании Российского этнографического музея, как источник для изучения традиционной культуры монголов	186
<i>Ц.Цэрэндорж</i>	
XV-XVIII зууны Солонгос сурвалж дахь Монголын түүхэнд холбогдох мэдээ баримтаас	204
<i>Д.Энхиэцэг</i>	
Монгол – Мингийн харилцаа: захидал бичгийн тухай	219
<i>Ц.Энхчимэг</i>	
“Төмөрийн цаазын бичиг”: Монголын эзэнт гүрний түүхийн чухал сурвалж болох нь	240
<i>Н.С.Яхонтова</i>	
Аспиранты из Монголии в Академии наук	250
Сведения об авторах	268
Зохиогчдын танилцуулга	272

Ц.Энхчимэг

**“ТӨМӨРИЙН ЦААЗЫН БИЧИГ”:
МОНГОЛЫН ЭЗЭНТ ГҮРНИЙ ТҮҮХИЙН
ЧУХАЛ СУРВАЛЖ БОЛОХ НЬ**

DOI 10.25882/fhdc-gn48

Тус илтгэлд Төмөр ноёны бичсэн хэмээгдэх “Төмөрийн цаазын бичиг” сурвалжийг авч үзэв. Тус “Төмөрийн цаазын бичиг” нь хоёр хэсгээс бүрдэх бөгөөд тэргүүн хэсэгт нь, зохиогч өөрийн намтар түүхийг өгүүлж, хоёрдугаар хэсэгт нь төр, цэргийг бэхжүүлэх тухай сургасан зүйлээ багтаажээ. Уг сурвалжид 1342 оноос 1405 онд хүртэлх Цагаадайн улсын түүхэнд холбогдох чухал үйл хэргүүдийг дурджээ. Энд бид Төмөрийн сургаалыг Чингис хааны билиг сургаалтай харьцуулан үзэж, Төмөрийг Чингис хааны байгуулсан төр улсын залгамж чанарыг улс төр, эдийн засаг, цэрэг-засаг захиргааны хувьд хэрхэн тээн авч явсан болохыг харуулахаар хичээв.

Түлхүүр үгс: Уложения Темура, монгольские рода, аймак, нукер, эмир, кошун, войска, ислам, шарият

Энхчимэг Ц.

**“УЛОЖЕНИЯ ТЕМУРА” КАК ВАЖНЫЙ ИСТОЧНИК
ПО ИСТОРИИ МОНГОЛЬСКОЙ ИМПЕРИИ**

В докладе рассмотрены “Уложения Темура”, написанные Тамерланом. “Уложения” состоят из двух частей. В первой части описывается жизнедеятельность самого автора, а вторая часть состоит из его наставлений относительно укрепления государства и войска. В “Уложениях” описаны события с 1342 г по 1405 г., имеющие ценное значение для истории Чагатайского улуса. Наставления Тамерлана рассмотрены в сравнении с наставлениями Чингисхана, что позволяет внести не только коррективы в политику Чагатайских ханов, но и рассматривать политическую, экономическую и военно-административную деятельность Тамерлана как преемника политики Чингисхана.

Ключевые слова: Цаазын бичиг, хууль цааз, Монгол овог, аймаг, нөхөр, эмир, хошуу, цэрэг, иргэн, Исламын шашин, шариятын хууль

2016 онд Төмөр ноёны (1336-1405) мэндэлсний 680 жилийн ойд зориулан Узбекистаны Шинжлэх Ухааны Академийн Дорно дахины хүрээлэнгээс эрхлэн “Төмөрийн цаазын бичиг”-ийн өмнө гарсан узбек, англи, франц, орос хэлний орчуулгыг нэгтгэн хэвлэж, нийтийн хүртээл болгожээ. Цагадай хэлээр бичигдсэн “Төмөрийн цаазын бичиг”-ийн жинхэнэ эх нь уламжлагдаж ирээгүй ч тус хүрээлэнд хадгалагдаж буй Мир Абу Толиб ат-Турбатын 1889-1890 онд хийсэн Перс орчуулгыг эх болгосон байна.

“Төмөрийн цаазын бичиг”-ийг XVII зуунд перс (фарси), XVIII зуунд франц, XIX зууны сүүлээр орос хэлнээ тус тус орчуулан гаргаж байв. Бид энэхүү илтгэлдээ “Төмөрийн цаазын бичиг” нь Монголын эзэнт гүрний түүхийн чухал ач холбогдолтой эх сурвалж болохыг өгүүлэхийг зорьсон болно. Энэхүү сурвалж бичигт Төмөр ноёны тогтоосон хууль цааз, намтар үйл ажиллагаа, түүний байгуулсан төр, цэргийн зохион байгуулалтын тухай өгүүлэхийн хамт мөн Төмөрийн билиг сургаал орсон байна.

“Төмөрийн цаазын бичиг”-ийн *нэгдүгээр хэсэгт* Төмөр өөрийн амьдрал үйл ажиллагааны тухай өгүүлэхдээ Цагадайн улсын түүхэнд шууд холбогдсон 1342 оноос 1405 он хүртэлх бүтэн жарны түүхэн үйл явдлыг тусгажээ. Төмөр ноён амьдралынхаа үйл хэргийг нийт 32 бэсрэг бүлэгт багтаан өгүүлснээс 25 бүлгийг дан цэрэг дайны үйл ажиллагаанд зориулсан байна. Үлдсэн 7 бүлэгт төр, цэргийн хүчээ бэхжүүлэх талаар авсан арга хэмжээний тухай тусгажээ.

Барлас овогт Тарагайн Төмөр (1336-1405) бол Цагадайн улсын Барлас аймгийн төв болсон Кашкадарья нутгийн Кеш буюу одоогийн Узбекистан улсын Шахрисабз хотын ойролцоох Хожа-Илгар тосгонд Тарагай ноёны хүү болон 1336 оны 4 дүгээр сарын 9-нд мэндэлжээ. Төмөрийн эцэг нь Чингис хаанаас хүү Цагадайдаа нэр заан томилсон 4 зөвлөх ноёны нэг Барласын Харачар ноёны 5 дахь үеийн удам бөгөөд Барлас аймаг нь Цагадайн улсын баруун хэсэг Мавераннахрт төвлөрөн сууж байв.

Түүх бичлэгт Төмөрийн улсыг Цагадайн улсын суурин дээр байгуулсан шинэ улс гэж үзэх хандлага ноёрхсоор ирсэн ч түүний байгуулсан улс анхнаасаа оноосон нэр үгүй, Алтан ургийн өргөмжилсөн хаантай, Цагадайн улсын засаг захиргааны хуваарь, төр-цэргийн зохион байгуулалтыг хэвээр нь үлдээж, Монголын төрт ёсны уламжлалыг даган мөрдөж байсан хийгээд Төмөр ноёны шат дараалан авч хэрэгжүүлсэн арга хэмжээнээс харахад тэрбээр шинэ улсыг бус харин Монголын

Цагадайн улсыг сэргээн мандуулсан гэж үзэх бүрэн боломжтой байна.

Цагадайн улсыг захирч байсан Их эмир Хусейнийг 1370 онд амь үрэгдэхэд Цагадайн ноёд, жанжингууд Их хуралдай хурж, Төмөрийг *түмний ноёноор* өргөмжилж, *Барласын* Харачар ноёны удам дамжин захирч ирсэн *түмнийг* түүнд захируулжээ. Энэ үеэс Эмир Төмөр Цагадайн улсын төрийн тавцанд голлох үүрэг гүйцэтгэх болов.

Цаашид Төмөр ноён Цагадайн улсын төрийн дээд эрхийг гартаа төвлөрүүлсэн ч өөрийгөө хаанаар өргөмжилсөнгүй, өргөмжлөх ч боломжгүй байв. Цагадайн улсын хаант төрийг уг удмынхан үеийн үед залгамжлан захирч ирсэн бөгөөд Алтан ургийн хүн л хаан болох ёстой гэсэн үзэл ард түмний мах цусанд бат шингэсэн байсан тул Төмөр Их хуралдай хуралдуулж, Алтан ургийн *Сургатмишийг* хаанаар өргөмжилжээ.

Төмөрийн хийсэн дараагийн алхам бол Цагадайн удмын Казан хааны охин, Их ноён Хусейний бэлэвсэн хатан *Сарай-мульк* ханумыг их хатнаа болгосон явдал байлаа. Ийнхүү Төмөр ноён Чингис хааны Алтан ургийн *хүргэн* болж, эрх мэдлээ хууль ёсны болгож чадав. Ийнхүү Төмөр “Эмир” цолын хамт “Хүргэн” гэсэн чимэг зүүх болов.

Төмөрийн хувьд Алтан ургийн хүргэн гэгдэх нь улс төрийн болон нийгмийн чухал ач холбогдолтой байсан тул түүний үр ач нар бүгд Алтан ургийн гүнж нартай ураг барилдаж “Хүргэн” хэмээх албан ёсны чимэг зүүж байсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй юм.

Их хуралдай нь Цагадайн улсын үед хаан өргөмжлөх, нийгэм улс төрийн тулгамдсан асуудлыг шийддэг дээд байгууллага байсаар ирснийг Төмөр ноён өвлөн залгамжилсан байна. “Хамгаас чухал нь *бүх ноёдын хуралдайг* тогтмол явуулж байхад оршино” гэж тэрбээр “Цааз бичиг”-тээ маш тодорхой тусган үр ач нартаа чанд захисан байна.

Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүний улсуудын төрийн үндсэн гол хууль нь “Их Засаг” байж, зүйл заалтыг нь биелүүлж байснаас Монголын төр, засаг бүхэлдээ тэр дундаа Цагадайн улсын төр, засаг хүчирхэг байсан билээ.

Цагадайн улс Исламын шашныг төрийн шашнаа болгосон хойно ч “Их Засаг” хуулийн олон зүйл заалтыг мөрдөн хэрэгжүүлсээр байв. Тухайлбал, Цаазын хулгайн тухай хэсэгт “Хулгайчийг хаана байхаас үл хамааран “Яса” [буюу “Засаг” - Ц.Э.] хуулиар шийтгэх ёстой” гэж Төмөр заасан байна.

“Цаазын бичиг”-ийн мэдээгээр Төмөр ноён төр захиргаа, цэргийн зохион байгуулалтын хэд хэдэн чухал өөрчлөлт хийв. Цагадайн улсын

төр ёсны уламжлалыг бага зэрэг өөрчилж, олон шат, зэрэг дэв бүхий цэрэг-иргэний зохион байгуулалттай болгов.

Их Монгол Улсын Мянганы систем нь нүүдэлчдийг захирахад тохирсон хэлбэр байсан бөгөөд алба гувчуур татах, дайн байлдааны үед тодорхой тооны цэрэг гаргах үүрэгтэй байв. Уг зохион байгуулалт нь Цагадайн улсын нийгмийн бүх давхаргыг хамарч байсны дээр асуудлыг шуурхай шийдвэрлэх бололцоог олгож байснаараа давуу байсныг Төмөр ноён хэвээр үлдээжээ.

Цагадайн улсад очиж суусан нийт монгол овог, аймгийн тоо Төмөрийн үед 12-рт хүрсэн гэж үзэх боломжтой байна.

“Миний захиргаанд буй 40 овог, аймгаас дор дурдсан *Барлас, Дархан, Арган, Жалайр, Дульхич, Дульдай, Могол, Сулдус, Тугай, Арлад* болон *Татар* зэрэг 12 аймагт тамгатай гэрэгэ олгож, *хувийн шадар нөхөр* ёсоор надад зүтгэхийг зарлигдав” гэжээ.

Өөрөөр хэлбэл, монгол угсааны 12 аймаг Төмөр ноёны *шадар аймаг* болж, түүний түших цэрэг, улс төрийнхүчний гол цөм нь болсон байна.

Чингис хаан 1206 онд Их Монгол улсыг байгуулахад хүчин зүтгэж, гавьяа байгуулсан үнэнч нөхөд, цэргийн жанжингууд, хөлөг баатруудыг мянгатын ноёноор томилсны нэгэн адил Төмөр ноён Цагадайн улсыг сэргээн нэгтгэхийн төлөө зүтгэсэн 313 үнэнч нөхөд, овог, аймгийн ноёд, баатруудаа “Эмир ноён”-оор өргөмжилжээ. “Миний хамгийн ойр дотнын 313 нөхдийг “Эмир ноёноор” өргөмжлөх зарлиг буулгав. Эд нар цөм сурвалжит гарал үүсэлтэй, хурц ухаан, эрч хүч, хатан зориг, сонор сэрэмжболон хянуур чанарыг өөртөө өв тэгш агуулсан бөлгөө. Эдгээр хүмүүсийн тус бүрд нь би өөрийн биеэр өв залгамжлагчдыг нь нэр заан томилсон бөлгөө. Амь үрэгдсэн Эмирийн орыг түүний нэр заагдсан өв залгамжлагчид нь шилжүүлнэ. Өв залгамжлагчийг “дэд эмир ноён гэх” ажээ.

Төмөрийн үед мянган цэрэг гаргах үүрэг бүхий нэгжийг Хошуу болгон өөрчилжээ. “Нэг Хошуу нь 1000, нэг Түмэн нь 10 мянга [буюу түмэн - Ц.Э.] цэрэг гаргах үүрэгтэй” гэж хуульчилснаар шинэ нэгж бий болгов.

“Төмөрийн цаазын бичиг”-ийн *хоёрдугаар хэсэг нь 30* бүлэгтэй. Эдгээр бүлэгт төрийн хийгээд цэргийн байгуулалтын талаар Төмөрийн тогтоосон хууль цааз орсон байна. Төмөр ноён байгуулсан улс, эзэлсэн газар нутгаа үр ач нартаа хуваан өгөхдөө тэд нарыг хувь улсдаа эзэн сууж төр, цэргээ хэрхэн удирдан жолоодох тухай нарийн тусгажээ. Төмөр ноён “төрийн хэргийн аравны есийг тунгааж болох, хэлэлцэж зөвлөлдөх

замаар гагцхүү аравны нэгийг л илдийн хүчээр шийдэж болно” хэмээн үзэж байсан хэдий ч улс орныхоо зэвсэгт хүчнийг бэхжүүлэхэд ихээхэн анхаарч байв.

Юуны өмнө төр, цэргийг удирдан захирах өөрийн мөрдлөг болсон 12 зарчмыг үр ач нартаа чанд сахихыг тэрбээр журамлажээ. Үүнд:

Нэгдүгээрт, улс орондоо миний үлдээж буй хууль цаазын эхнийх нь лүндэн буулгагч Мухаммедын шашин болон шариатын хуулийг цэцэглэн хөгжүүлэхэд бүх талаар дэмжих. Исламын шашныг хасаагүй хэзээд дэмжиж байх.

Хоёрдугаарт, 12 язгуур угсаа, овог аймгийн дэмжлэг туслалцаагаар олон орныг эзлэн захирч, тэдний хүчээр улс орныхоо тулгуурыг бэхжүүлж, Хуралдайг тэд нараар чимж байв.

Гуравдугаарт, заавар зөвлөгөө, мэргэн ухаан, арга заль, овсгоо самбаа, хэрсүү үйлдлээр би дайсны талын түмэн цэргийг дарж, улс орныг дагуулсан билээ. Төрийн хэргийг хүндэтгэлтэй, өршөөлтэй болон хүлээцтэй явуулж байв. Нуун далдалсан юмны талаар мэдэж байсан ч мэдээгүй юм шиг байдаг байв. Дайсан ба нөхрийн аль алинтай нь эвтэй байхыг хичээх нь чухал.

Дөрөвдүгээрт, төрийн хэргийг тогтсон хууль цааз, ёс заншилд үндэслэн явуулснаар нэр хүндээ өдийчинээ бэхжүүлэх аваас Эмир ноёд, сайд түшмэд, цэрэг дайчид, харц ард өөрийн аж байдал, хэргэм зэрэг, цол тушаалдаа сэтгэл хангалуун болдог жамтай.

Тавдугаарт, өрлөг жанжингууд, цэрэг дайчиддаа алт, эрдэнэсийг харамгүй соёрхож, найр наадам дээр хүндтэй суудалд зална. Ингэх аваастэд дайны талбарт амь насаа үл хайрлан тулалдах болно. ... Өрлөг жанжингууд, баатар эрсийнхээ эр зориг, гавьяа зүтгэлээр 27 орны хааны сэнтийг илдийн хүчээр буулган авсан болой...

Зургадугаарт, буруутан болон буруугүй этгээдийг аль алийг энэрэн хэргийг нь үнэнч шударгаар тасалж байв. Хууль ёсыгчанд мөрдөж, цэрэг, харьяат албатыг итгэл, айдас хоёрын завсар барьж байв. Ядуус үгээгүйчүүдийг энэрэн хайрлаж, дайчдад хишиг харамгүй түгээж байлаа. ...

Долоодугаарт, сайид, эрдэмтэн мэргэд, шейх, хууч хөөрөгчид (түүхчид)-ийг хүндэтгэн үзэж, тэднийг таалан соёрхож байв...

Наймдугаарт, шийдэмгий баттай хөдөлж байлаа. Аливаа зүйлийг хийхээр зоривол санасандаа хүрч байж санаа амардаг байв.

Есдүгээрт, харьяат албатынхаа аж байдлын талаар сураглаж байв... Орон тус бүрийн ард иргэдийн аж байдлын талаар мэдээлэлтэй байж,

муж тус бүрийн албат нарын санаа сэтгэл, үйл хэрэг, зан авир хийгээд цэрэг дайчид болон тэд нарын хоорондын харилцаа холбооны талаар надад мэдээлж байх үнэнч, хичээнгүй түүх бичигчийг томилон суулгадаг байлаа. Захирагч ноён, цэрэг дайчин эсвэл албатаас хэн нэгэн ард түмнийг хавчин дарласан тухай мэдмэгц цаг тухайд нь шударга ёсоор шийтгэж байлаа.

Аравдугаарт, миний ивээлд орсон түрэг, тажик, араб, перс язгуур угсааны болон овог аймгийн тэргүүлэгчдэд хүндэтгэл үзүүлж явав.

Арван нэгдүгээрт, төрийн эрх мэдэл, эд баялгийн оргилд хүрээд хөвгүүд, садан төрөл, нөхөд, хамтран зүтгэгчид, сайн санаат хүмүүсээс хэнийг ч марталгүй ачийг нь хариулсан болой.

Арван хоёрдугаарт, цэрэг эрсийн надад хандах хандлагаас эс хамааран би тэд нарыг хэзээ ямагт хайрлан халамжилж ирсэн болой. Учир нь тэд миний төлөө алтан амиа золиослон дайн тулаанд ордог хүмүүс билээ.

Хэрэв дайсны цэрэг эзэндээ үнэнчээр зүтгэж, миний эсрэг илдээ сугалбалби таалан соёрхож байлаа. Ийм хүнийг надад чин үнэнчээр зүтгэнэ гэдэгт баг итгэлтэй байсан тул миний талд орсон хойно гүн итгэл үзүүлдэг байв.

Ийнхүү, “Төмөрийн цаазын бичиг”-ийн **хоёрдугаар хэсгийн 30** бүлгээс 14 нь цэрэг, дайны холбогдолтой, 11 нь төр, улсыг удирдан жолоодохтухай, 2 нь Ислам шашны холбогдолтой, 2 нь Төмөр ноёны үр ач нартаа цэрэг иргэн оногдуулах болон тэд нарыг төрийн эсрэг гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд оноох ял шийтгэлийн тухай байна.

Төр, засаг захиргааны зохион байгуулалтын талаар

Төрийг тогтвортой байлгахад хамгаас чухал нь *бүх ноёдын хуралдайг* тогтмол явуулж байхыг үр ач нартаа Төмөр анхааруулж байна. “*Санасан хэргийнхээ сайн, муу талыг, гарах үр ашиг, гарз хохирлыг болон тухайн хэргийг хийх эс хийхийг Их хуралдайгаар хэлэлцэж, ноёдын санаа бодлыг би тун анхааралтай сонсдог*” гэжээ.

Өөрөөр хэлбэл, Чингис хаанаас хойш тогтсон улс орны эрх ашигтай холбоотой амин чухал асуудлыг урьдчилан зөвлөлдөж их хуралдайгаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг уламжлал Төмөрийн үед ч хэвээр байсан байна.

Хуралдай дээр ноёд, жанжингууд, эрдэмтэн мэргэд, шашны мяндагтнууд болон Төмөрийн үр ач нарын эзлэх суудлыг “Цаазын бичиг”-т тодорхой зааж өгсөн байна. Тухайлбал, “*Миний үр ач*

нар, төрөл төрөгсөд сэнтийг хүрээлж сууна. Шашны мяндагтнууд, эрдэмтэн мэргэд, эмирууд, ноёдууд, жанжингууд, аймаг, түмэн, хошууны толгойлогчид, мянга, зуут, аравтын дарга нар зэрэг дэвээрээ миний зүүн талаарх суудлыг эзэлнэ. Везир буюу Ерөнхийболон бусад сайдууд сэнтийн өмнө сууна. Тэдний араар хот, суурингуудын захирагчид байраа эзэлнэ. Алдар нэрээ мандуулсан эрэлхэг баатрууд болон гарамгай дайчид сэнтийн баруун талаар, харуулын дарга нарыг сэнтийн зүүн хойд талаар суухыг зарлигдав” гэжээ.

Төмөрийн үед Төрийн захиргаа нь (Девони бузург) 7 сайдаас бүрдэж байв. Сайд тус бүр тус тусын алба үүрэг хүлээж байв. Төр иргэний асуудал эрхэлсэн сайд ургац болон алба татварын асуудлыг эрхэлж байсан бол цэргийн сайд улсын хэмжээний цэрэг дайны хэргийг хариуцах аж. Сангийн асуудал эрхэлсэн сайд, худалдааны асуудал эрхэлсэн сайд зэргээс гадна шашны дээд шүүгч - кази, иргэний болон цэргийн санал гомдол хүлээж авах түшмэл - арзбег, шашны сүм хийдийн өмч хөрөнгийн асуудал эрхэлсэн түшмэл - садр азам, Исламын шашны шариатын хуулийг сахин хэрэгжүүлэгч шейх ул-ислам, иргэний хэргийн ерөнхий шүүгч - казиал - кузат зэргийг нэрлэж болно.

Төмөрт олзлогдсон Арабын түүхч Ибн Арабшахын тэмдэглэснээр “Төмөр дөрвөн Ерөнхий Сайдтай. Тэд цөм сурвалжит удмын хүмүүс тул бүгд тэдний саналыг дагана. Эдгээр Ерөнхий Сайд нар тус тусын овог аймгаа төлөөлж, овог аймгийнхаа үзэл бодол, оюун санааг нь хэрэгжүүлж явна. Овог аймгийг нэгийг **Арлат** гэнэ, нөгөөг **Жалайр**, гуравдахийг **Кавчин (Хуучид - Ц. Э.)**, дөрөвдэхийг **Барлас** гэнэ. Төмөр болбоос энэхүү дөрөвдэх аймгийн хүн болой” гэжээ.

Муж, хот болон дүүргийн захирагч - хокимууд - өөрийн хариуцсан газар нутагт журам сахиулах, сувиллын газар, нийтийн халуун усны газар, дэн буудал, өртөө, зээлийн газрын хэвийн үйл ажиллагааг хангах зэрэг үүрэг хүлээж байжээ.

Төр, цэргийг удирдан жолоодоход өөр нэг анхаарах зүйл бол “Эрдэмтэд, мэргэд, шашны алдарт зүтгэлтнүүд, жанжин, цэрэг дайчид болон жирийн иргэд, сайд түшмэд, эмч зурхайчид, түүхч сударчид, аянчин гийчид, өтгөс өвгөд, гар урчууд гэсэн 12 язгуур угсааг түшиг тулгуураа болгох нь чухал” гэж “Хууль цаазад” тусгажээ.

“Улс, хошуун, түмтийн эмир ноёдыг дэвшүүлэх тухай” хэмээх бүлэгт байгаа мэдээ нь мөн Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдоно. Үүнд:

“Миний захиргаан дор байгаа 40 аймгаас Барлас, Дархан, Арган, Жалайр, Дульхич, Дульдай, Могол, Сулдус, Тугай, Арлад болон Татар

нарын 12 аймагт миний овгийн тамгатай гэрэгэ олгож, хувийн шадар нөхрийн ёсоор зүтгэхийг зарлигдав.

Барласын 4 ноёныг Тэргүүн Эмир-ээр томилж, Эмир Худайдадад Бадахшаныг, Эмир Жак, Эмир Их Төмөр болон Эмир Сулайман-шаг нарт тус тусад нь нэжгээд хязгаар муж тойргийг олгов. **Барлас аймгийн** 100 хүнийг *мянгатын даргаар* тохоон томилж, Эмир Жалалудиныг *10-р зэргийн Эмирээр*, Эмир Абу Сайидыг *9-р зэргийн Эмирээр* тус тус дэвшүүлэн томилов.

Дархан аймгийн Баязидийг *7-р зэргийн Эмирээр* дэвшүүлэн томилохын хамт тус аймгийн 20 хүнийг *зуутын даргаар* тавив.

Аргын аймгийн Дашхожаг *8-р зэргийн Эмирээр* өргөмжлөн мөн аймгаас ахин 20 хүнийг *мянгат, зуут болон аравтын даргаар* тохоон томилов.

Жалайр аймгийн Тугтөмөр, Шир Бахрама нарыг *8-9-р зэргийн Эмирээр* өргөмжилж, тус аймгийн 20 хүнийг *зуут, аравтын даргаар* тохоон томилов.

Дулкичи аймгийн Өлзийт Апердийг *Эмир ноён* болгов.

Дульдай аймгийн Таван бахадур болон Санбаатар нарыг мөн *Эмир ноёноор* өргөмжлөв.

Могол аймгийн Төмөрхожа огланыг *Эмир ноёноор* дэвшүүлэв.

Сулдус аймгийн Илчи баатарыг *Эмир ноёны албан* тохоон томилов.

Тугай аймгийн Али Дервишийг мөн *Эмир ноён* болгов.

Кипчак аймгаас Сарбөхийг *Эмир* болгов.

Миний эгчтэй гэрлэсэн **Арлат аймгийн** Эмир Муайядыг *Ерөнхий Эмир ноёноор* өргөмжлөв. Мөн аймгийн Салайчи Бахадурьг *Эмир ноён* болгов.

Татар аймгаас Кунак-ханыг *Эмир ноён* болгов.

Төмөр ноёны овгийн тамгатай Гэрэгэ олгоогүй бусад 28 аймгийг дээр дурдсан “улс хариуцсан эмир ноёдын мэдэлд шилжүүлэн энэхүү “Цаазын бичиг”-ээр тогтоосон тооны морин цэргийг дайны цагт гаргахыг зарлигдав” гэжээ.

Дээр нэр нь гарсан Барлас, Жалайр, Сулдус, Арлад зэрэг Монгол 12 аймгийн Их ноёдод Төмөр өөрийн овгийн тамгатай бичиг олгож, андын барилдлагатай аймаг болгон дэвшүүлжээ. Нэр бүхий 12 аймгийн 20 ноёныг Эмир болгон дэвшүүлэн, Барлас, Жалайр, Арган, Дархан зэрэг язгуурын 4 монгол аймгаас 160 хүнийг *мянгат, зуут, аравтын даргаар* тохоон томилсон нь Төмөр ноён цэргийн удирдах бие бүрэлдэхүүнийг дан монголчуудаар бүрдүүлж байсныг нотлон харуулж байна.

Мөн Эмир цолыг цэргийн дарга нарт олгох бөгөөд уг цол нь 10-аас 1-р зэрэг хүртэл 10 зэрэг дэвтэй байснаас Тэргүүн ба Ерөнхий эмир гэсэн ноёдын хамгийн дээд зэргийн цолыг Төмөрийн төрөл садан, ойр дотнын ноёд хүртсэн байна.

Төмөр ноён Чингис хааны нэгэн адил амьд сэрүүндээ эзлэгдсэн орны газар нутгийг дөрвөн хөвгүүддээ хувааж өгсөн байдаг. Мөн тэд нарт цэрэг иргэнийг оногдуулахдаа энэхүү “Цаазын бичиг”-ийн дагуу шийдвэрлэжээ.

“Манай ахмад хөвгүүн, их ор залгамжлах Мухаммад Жахангирт 12 мянган цэрэг иргэн, нэг (вилайет) муж нутаг.

Манай 2 дахь хөвгүүн Омар-Шейх-д 12 цэрэг иргэн, нэг муж нутаг.

Манай 3 дахь хөвгүүн Мираншахад 9 мянган цэрэг иргэн, нэг муж нутаг.

Манай 4 дэх хөвгүүн Шахрухад 7 мянган цэрэг иргэн, нэг муж нутаг тус тус олгов.

Манай ач нарт авьяас чадварынх нь дагуу 3-аас 7 мянга хүртэл морьтон цэрэг, нэжгээд муж нутгийн хамт оногдуулав” гэжээ. Монгол хаадын үр ач нартаа газар нутаг, ард иргэдийг оногдуулдаг уламжлалыг Төмөр ноён хуульчлан баталсан байна.

“Их үйл хийхээр шийдсэний дараагаар би бээр Куран судраар төлөг тавьж, сударт зааснаар хөдөлдөг. Туглагтөмөр хаан дээр очихынхоо өмнө би Куран судрыг нээхэд “Юсуфын сура” дээр таарав (Аллах бурхан өршөөх болтугай). Иймд би тэнд заасан ёсоор болгосон юм” гэжээ. Чингис хаан их үйл бүтээхийн өмнө хонины далаар төлөг тавьдаг байсанчлан Төмөр ноён ч мөн Куран судраар мэргэлдэг байсан нь монгол уламжлалын илрэл бололтой.

Эцэст нь, Төмөрийн тогтоосон “Цааз бичиг”-ийг “Төмөрийн билиг сургаал”, “Төмөрийн дурдатгал”, “Уложение” буюу “Хууль цааз” хэмээн олон янзаар орчуулсан ирсэн бөгөөд бид “Цаазын бичиг” хэмээх орчуулга нь уг сурвалжийн утга агуулгад нийцсэн гэж сонгон авсан болно.

Ийнхүү “Цаазын бичиг”-ийг бүхэлд нь авч үзвэл Төмөрийн тогтоосон төр, цэрэг, нийгэм, эдийн засаг, засаг захиргаа, хууль цааз, өртөө зам, олон улсын худалдаа, шашны харилцаа буюу нийгмийн бүхий л харилцааг өргөн хүрээгээр хуульчилсан байгаа бөгөөд энэхүү хууль цааз нь Монгол хаадын төр, цэргийн бодлоготой үзэл санаа болон агуулгын хувьд дүйцэж байна. Энэ утгаар Төмөрийн “Цаазын бичиг” нь Цагадайн улсын төдийгүй Монголын эзэнт гүрний түүхийн чухал эх

сурвалж бөгөөд дундад зууны монголчуудын хууль цаазын үнэт баримт бичиг болж байгаа юм.

Ном зүй:

Уложения Темура (Темур тузуклари). Ташкент. Издательство литературы и искусства имени Гафура Гуляма. 1996.

Караматов Х. *Уложения Темура*. Ташкент. Издательство литературы и искусства имени Гафура Гуляма. 1999.

Уложения Темура / под. ред. Р. Азимовой. – Ташкент. Чулпан. 1992.

Ибн Арабшах. *Чудеса суд*. Зафар-намэ. Ташкент. 2008.

Цахилгаан Д., Шагдар Х. *Доголон Төмөр*. Боть 38. УБ. 2006.

Ц.Энхчимэг. *Монголын Цагадайн улс*. УБ. 2006.

Ц.Энхчимэг. *Монголын Цагадайн улс // Монголын эзэнт улсын түүх – IV*. УБ. 2019.

Ц.Энхчимэг бусдын хамт. *Төмөр Монгол төрийн зүтгэлтэн биш гэж үү?* // Оюуны хэлхээ. 2014. II (12).

Ц.Энхчимэг. *Цагадайн улсын угсаатны бүрдлийн асуудалд: Барлас аймаг // ОХУ-ын Буриадын их сургуультай хамтран Их засаг олон улсын их сургуулиас зохион байгуулсан “Улымжиевын нэрэмжит уншлага-IX” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. Улаан-Үд-Улаанбаатар. 2017.*